

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД
МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-9

1. “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл	4-5
2. “Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төсөл	5-6
3. “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” Түр хорооны тогтоолын төсөл	6-9

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 11 дүгээр сарын 12-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Болормаа.

Нэг. “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Батнайрамдал: “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

70.0 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал “Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Батнайрамдал: “Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Түр хорооны дарга О.Батнайрамдал “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ө.Шижир нарын тавьсан асуултад Түр хорооны дарга О.Батнайрамдал хариулж, тайлбар хийв.

О.Батнайрамдал: “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0

Бүгд: 10

100 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

“Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга, мэдээллийг сонсох асуудлыг Түр хорооны хуралдаанд “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийнхан ирээгүй тул хойшлуулав./15:49/

Түр хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 27 минут үргэлжилж, 11 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 91.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 22 минут.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Батнайрамдал: Эрхэм гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Оюу толгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 11 сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Манайхан надад алх байхгүй. Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн, Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн Даваахүүгийн Пүрэвдаваа, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир, Отгоншарын Батнайрамдал гэсэн 81,8 хувийн ирцтэй өнөөдрийн хуралдаан эхэлж байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд, Түр хорооны тогтоолын төслийг бид батлах байгаа. Түр хорооны сонсголын товыг зарлах тухай тогтоолын төсөл, мөн Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай тогтоолын төсөл, мөн Түр хорооны сонсголд гэрчээр дуудах иргэн, албан тушаалтны нэрсийг батлах тухай тогтоолын төсөл. 2 дугаарт нь Оюу толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга, мэдээллийг сонсох гэсэн асуудлууд өнөөдрийн хуралдааны товд орсон байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Арай алх авчраагүй байна. Тэгэхгүй бол энэ дараа нь протоколын алдаа гарах вий дээ энэ дээр. Алх иртэл түр хүлээе. Алх ирчихсэн байна.

Нэг. “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Эхний Түр хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна. Түр хорооны сонсголын товлон зарлах тухай тогтоолын төсөл. Түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тов тогтоох тухай тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиас 35.4-д Түр хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Түр хороо зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой асуудлаар тогтоол батална. 45.1-д Түр хороо сонсголын товыг нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ гэж заасан байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан. Тогтоол, товыг 2025 оны 12 сарын 8-наас 12-ны хооронд зохион байгуулахаар тогтоолын төслийг та бүхэнд өгсөн

байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Гишүүд үг хэлж, дууслаа.

Сонсголын тов тогтоох тухай тогтоолын төслийг та бүхэндээ уншиж танилцуулъя. Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1А дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, мөн зүйлийн 35.4 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг дараах өдрүүдэд зохион байгуулахаар товлосугай.

1 дүгээрт, 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Жавхлант, Шивээ толгой ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг тогтоож, үнэлгээг тодорхойлсон болон холбогдох бусад баримтад үндэслэн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох холбоотой асуудал. 2 дугаарт, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Оюу толгой компанийн хувь нийлүүлэгчдийн гэрээ нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон, түүний санхүүжилтийн хүүгийн хувь, түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагавраар. 3 дугаарт, 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Оюу толгой компанийн хувь нийлүүлэгчдийн гэрээ нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосны санхүүжилтийн хүүгийн хувьд түүнийг олон улсын зах зээлийн жишигт нийцүүлэн бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох үр дагавар, үргэлжлэл.

Хоёрдугаарт, Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг товлосонтой холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сонсголын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдалд даалгасугай гэсэн Түр хорооны тогтоолын төслийг та бүхэндээ танилцууллаа.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Санал хураалт. Нийт гишүүдийн 70 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдлээ. Гишүүдэд баярлалаа.

15.37 цаг

Хоёр. “Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Түр хорооны тогтоолын төсөл

2 дугаарт Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай тогтоолын төсөл байгаа. Дараалал тогтоох энэ төсөл маань буцаад нэрс, гэрчийн нэрсийн жагсаалттайгаа холбогдоно. Гэрчийн нэрс дуудагдахдаа дараалал буюу дэд сэдэвтэйгээ холбоотойгоор яг юугаар дуудах гэж байгаа гэдгийг илүү ойлгомжтой байх үүднээс Дараалал тогтоох тухай тогтоолын төсөл батлагдах ёстой байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 48.1-д сонсголыг үр дүнтэй явуулах, ялгаатай байр суурийг шударгаар илэрхийлэх боломж олгох, Түр хорооны бүрэлдэхүүн дэх нам, эвслийн төлөөлөл асуулт тавих эрхийг нь тэнцвэртэйгээр эдлүүлэх үүднээс гэрч, шинжээч, хянан шалгагчаас мэдүүлэг, тайлбар авах, хянан шалгагчийн тайлан болон шинжээчийн дүгнэлтийг сонсгох, бичмэл болон бусад нотлох баримтуудыг уншиж сонсгох, шинжлэн судлах дарааллыг тогтооно. Мөн 48.2-т энэ хуулийн 48.1-д заасан дарааллыг Түр хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ гэсэн байгаа.

Тогтоолын төсөл та бүхэнд тараагдсан. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Тогтоолын төсөлтэй дараалалтай холбоотой, дараалал. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай төслийг та бүхэндээ уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, мөн зүйлийн 35.4 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг хавсралтаар баталсугай.

Хоёрдугаарт, нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг баримталж, сонсголын дэгийг сахиулахыг Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдалд даалгасугай гэсэн тогтоолын төслийг хавсралттай та бүхэнд танилцуулж байна. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Болсон байна. Тийм, тэгээд дуусаж байгаа. Санал хураалт. Нийт гишүүдийн 70 хувь дэмжсэнээр тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүдэд баярлалаа.

15.37 цаг

Гурав. “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Дараагийн тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя. Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, мөн зүйлийн 35.4 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг, 38.4 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.3.5 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Нотлох баримтыг шинжлэх, судлах хянан шалгах түр хорооны сонсголд гэрчээр дуудах иргэн, албан тушаалтныг хавсралтаар баталсугай.

Хоёрдугаарт, Хянан шалгах түр хорооны сонсголд гэрчээр дуудах мэдэгдлийг хавсралтад заасан иргэн, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдалд үүрэг болгосугай.

3 дугаарт, тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хянан шалгах түр хорооны сонсголд нэмж гэрчээр дуудах нэрсийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.7.4-т заасны дагуу шийдвэрлэхийг Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдалд даалгасугай гэсэн Түр хорооны сонсголын гэрчээр дуудах тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна. Хавсралтад сонсголд гэрчээр дуудах иргэн, албан тушаалтны нэрсийг бүгдийг нь жагсаалтаар та бүхэнд оруулсан хүргэсэн байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Шижир гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Ойлголоо, баярлалаа. Энэ нөгөө албан тушаалаараа дуудагдаж байгаа тухайн үеийн процессууд юм шиг байна гэж ойлголоо. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүний хувьд энд дуудагдсан байна л даа Б.Бат-Эрдэнэ гээд 43 дээр. Энэ нөгөө 164 дээр Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ гэхихсэн энэ бодвол Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ юм шиг байна гэж би ойлголоо. Тийм нөгөө тухайн үеийн Балдан-Очир, Дамба-Очир, Дэмбэрэл гээд ингээд явж байгаа учраас. Тэгэхээр энэ бол надтай хамаагүй юм шиг байна. Өөр юман дээр байхгүй байх шиг байна. Тэгэхээр би чинь өөрөө Хянан шалгах түр хороонд ажиллаж байгаа. Тэр өдөр сонсголд өөрөө оролцох ёстой, яаж оролцох вэ, гэрчээр оролцох юм уу, хянан шалгах түр хорооны гишүүнийхээ хувиар оролцох юм уу гэдэг дээр асуулт асуух гэсэн юм? Заагийг нь гаргаад өгөөч гэж.

Нэмэлтээр хэлэхэд тухайн үед Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхад Оюу толгойтой холбоотой аливаа асуудалд оролцож байгаагүй шүү дээ бид нар. Яах вэ тодорхой хэмжээнд ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ, устай холбоотой асуудлууд гэдэг ч юм уу тиймэрхүү юман дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам тухайн үеийн нэрээр одоогийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам бол одоо ч ажиллаад явж байгаа. Засгийн газраас гарсан тодорхой хэмжээний тогтоол, тэмдэглэл ч юм уу магадгүй нэг ажлын хэсэг байгуулсан тогтоол, тэмдэглэл дотор нэр орчихсон байхыг үгүйсгэхгүй тухайн үеийнхээр. Тэгээд тэр утгаараа магадгүй дуудагдаж байгаа болов уу, гэрчээр дуудагдаж байгаа болов уу гэж бодож байгаа, тэгэхээр бодож байна. Тэгэхээр энэ дээр нэг мэдээлэл өгөөч гэж асуух гэж байгаа юм.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ бид нарын хянан шалгах үйл ажиллагаа бараг 2006 оноос хойш гэхээр чинь сүүлийн бараг 20 гаруй жилийн туршид Оюу толгойтой холбоотой янз бүрийн ажлын хэсэг гарсан, ажлын тайлангууд, холбогдох баримтууд дээр жишээлбэл ажлын хэсэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар та ажлын хэсэгт тэн дотор орчихсон тушаал дотор орчихсон учраас л энэ гэрчийн нэрс дотор орж дуудагдаж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ дээр харшилж байгаа зүйл хуулийн хүрээнд байхгүй. Бид Хянан шалгах түр хорооны гишүүд орохдоо бол яг хуулиараа хувийн ашиг сонирхолгүй гэж бүгдээрээ бид бүхэн хэлж орсон. Тэгэхээр хувийн ашиг сонирхолгүй, харин зүгээр албан тушаалаар энэ чинь 20 жилийн турш мэдээж нэг хүн ганц албан тушаал хашихгүй шүү дээ. Маш олон албан тушаал тухайн үедээ хашиж байсан, 20 хүний ажлын хэсэгт нэгд нь орчихсон тэгээд л дуудагдаж байгаа гэсэн хэлбэр юм.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн хуулийн асуудал байхгүй. Тэгэхээр та Хянан шалгах түр хорооны гишүүнийхээ ажлаа хийгээд л, тухайн үед яг тэр ажлын хэсэг гэрчээр дуудагдах тэр үед гэрчээр шаардлагатай бол асуултад хариулж болно. Бусад үед Түр хорооны гишүүнээр ажиллахад ямар нэг асуудал байхгүй юм байна лээ. Асуудалгүй гэсэн үг. Бат-Эрдэнэ гишүүн нэмж тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ер нь Оюу толгойтой холбоотой асуудал улс төржилт ихтэй. Би санаа зовж байгаа зүйл нь юу вэ гэхээр сүүлд Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд магадгүй жишээлбэл тодорхой албан тушаал хашиж, гэрчээр дуудагдаж байсан нөхдүүд өөрсдөө орсон байсан гэдгээр Хянан шалгах түр хорооны өнгөрсөн 4 сар гаруй, 12 сард гэвэл ингээд бараг 5 дахь сар луугаа орох байх, 5 сар гаруйн энэ олон хүмүүсийн хийсэн үйл ажиллагааны үр дүнг баллуурдчих вий дээ, тийм нөхцөл байдал, эрсдэл байхгүй биз дээ гэдэг дээр л асууж байгаа юм. Хувь хүнээс гэхээсээ илүүтэй.

О.Батнайрамдал: Бат-Эрдэнэ гишүүн чухал асуудлыг хөндөж байна л даа. Тэгэхээр ер нь Хянан шалгах түр хорооны процесс, сонсгол бол өөрөө хэн нэгнийг албан тушаалтныг тухайн албан тушаалаа хашиж байсан учраас байцаах биш, энэ бол илүү тухайн холбогдох нотлох баримттай холбогдуулан нэмэлт асуулт асууж, илүү олон нийтийн өмнө өөрсдийн үнэн зөв байраа илэрхийлэх боломж. Тийм болохоор энийг бид бүхэн ямар нэгэн улс төржих өнцөг ч юм уу, эсвэл хэн нэгнийг байцааж, эсвэл тухайн үед ийм албан тушаал хашиж байсан учраас гэдэг агуулгаар биш, энэ бол нэмэлт мэдээллийг тухайн ажилд оролцож явахдаа тухайн гэрчээс мэдүүлэг авах маягаар сонсголыг зохион байгуулдаг байгаа юм.

Тийм учраас энэ дээр мэдээж олон албан тушаалтан, сүүлийн 20 жил гаруй Оюу толгойтой холбоотой ажлын хэсэгт орсон гишүүд, ажлын хэсгийн дарга нар, холбогдох бичиг баримт гаргаж байсан албан тушаалтнууд нэмэлт материал дээр нотлох баримт шаардлагатай учраас гэрчийн нэрсээр орж сонсгол дээр хүрэлцэн ирж, илүү үнэн зөвөөр өөрсдийнхөө байр суурийг тухайн үедээ илэрхийлэх бас том талбар боломж гэж ер нь хуульдаа ч гэсэн тэгж байгаа юм л даа. Сая хууль уншиж байхдаа, хуулийн заалт уншиж байхад илүү тэнцвэртэй мэдээллийг хангахад тухайн хүний байр суурийг гэрчийн мэдүүлгээр сонсох хүрээнд явах ёстой юм. Тийм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн асуудал байхгүй болов уу. Ер нь урд явж байсан сонсголууд дээр ч гэсэн Түр хорооны гишүүн гэрчээр дуудагдаад, гэрчийн асуултад хариулж байсан тохиолдол гарч л байсан юм байна лээ. Тэгэхээр асуудалгүй болов уу л гэж бодож байна. Баярлалаа. Шижир гишүүний асуулт.

Ө.Шижир: Асуулт нь ерөнхийдөө давхацчихлаа. Гэхдээ энэ дээр нэг юм хэлэхгүй бол. Жишээ нь би 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байхад тухайн үед 2021 оны 02 дугаар сарын 09-ний Монгол Улсын Ерөнхий сайдын 45 дугаар захирамж гарсан юм. Энэ захирамж нь тухайн үеийн Хууль зүйн сайдаар ахлуулаад Оюу толгой төслийн гаднын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийх нэг ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн гээд. Тэгээд тухайн үед Засгийн газартай зөвшилцсөнөөр гээд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга гээд ингээд хэдэн бүрэлдэхүүн рүү өөрчлөлт оруулсан л даа.

Тэгээд намайг Тамгын газрын даргаар ажиллаж байх хугацаанд энэ ажлын хэсэг нэг ч удаа хуралдаагүй буюу би энэ процесст Ерөнхий сайдын захирамж дээр нэр байгаа ч гэсэн энэ ямар нэгэн процесст оролцоогүй гэсэн үг. Тэгээд түүний

араас 6 сарын 25-ны өдөр би үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, халагдсан чөлөөлөгдсөн. Тэгээд түүний араас одоо энэ Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичиг дарга Содбаатар миний ажлыг авсан юм. Тэгээд Содбаатар дарга ингээд гэрчээр дуудагдаж байгаа юм шиг байна тийм үү? Тэгэхээр нөгөө нэг болоогүй хурал, хийгээгүй ажил, тэгээд тухайн хэдийгээр ажлын хэсэг дээр нь нэр нь орсон ч гэсэн энэ хурал нь намайг ажил хийж байх хугацаанд бол нэг ч хуралдаагүй. Содбаатар дарга миний ажлыг үргэлжлүүлж аваад хэд хуралдсаныг би мэдэхгүй байна.

Тэгээд асуулт ерөнхийдөө Бат-Эрдэнэ гишүүнийхтэй адилхан. Тэгээд би энэ дээр тайлбар заавал протоколд хэлүүлж байгаа юм. Тийм.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр та бараг гэрчийн нөгөө мэдүүлгээ өгчих шиг боллоо л доо. Ер нь яг ажил, тухайн үед ингээд ажлын хэсэгт орсон гишүүн болгон энэ гэрчийн нэрс дээр бол хянан шалгагч шинжээч нараас ирж байгаа юм байна лээ. Тэгэхээр яг тийм, тэгэхээр яг адилхан гэсэн үг л дээ. Тэгэхээр нэмэлт мэдээлэл өгөхөд яг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 38 дугаар зүйл дээр гэрчийг юу гэж тодорхойлдог вэ гэхээрээ тусгай шалгах асуудал үйл баримтад, үйл баримтыг нягтлан тодруулахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэх хүн л гэж тодорхойлсон байгаа юм. Тэгэхээр хянан шалгах шинжээчдийн үйл явцад процесс дээр нэмэлт мэдээлэл хэрэг болсон тэр баримтын хүрээнд тухайн үед ажлын хэсэгт жишээлбэл 20 гишүүн орсон бол тэд нар энэ хянан шалгах шинжээчийн нэрст ороод л дуудагдаж байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ давхцаагүй нэрс, давхцаагүйг нь аваад тооцвол ойролцоогоор 301 хүн Оюу толгойн энэхүү сонсголд дуудагдаж байгаа. Тэгээд энийг маргааш тогтоол маань албажаад, олон нийтэд тавигдахад бүх хүмүүсийн нэрсийг олон нийт маань харах боломжтой болно. Баярлалаа. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье. Пүрэвдаваа гишүүн ороогүй байна та. Санал хураалт. Нийт гишүүдийн 100 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа. Гишүүдэд баярлалаа.

15.48 цаг

Тов дараалал хаана байна вэ. Дараагийн асуудалдаа оръё. Тийм болчихсон, одоохон. Дараагийн асуудал маань Оюу толгой компанийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага хүрэлцэн ирэх ёстой байсан. Өнөөдрийн хуралдаанд бас хүрэлцэн ирсэнгүй. Өнөөдрийн хуралдаанд уул нь урьд өмнөх хуралдаанууд бол дандаа хүрэлцэн ирэх боломжгүйгээ албан тоотоор, эсвэл и-мэйлээр хэлдэг байсан бол энэ удаа и-мэйл ч байхгүй байна. Тэгээд дараагийн хуралдаан дээр Оюу толгой компани өөрсдөө ирж, танилцуулгаа хийх болов уу гэж найдаж байна. Парламентад хэрвээ дуудсан бол заавал ирэх ёстой. Тийм учраас дараагийн хуралдаан хүртэл Оюу толгой компанийн танилцуулгыг дахин хойшлуулж байна.

15.49 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА